

2007/01/26

УРАЛДААН ЗАРЛАЖ БАЙНА

Монгол, Япон хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 35 жилийн ой болон “Японы жил” арга хэмжээний хүрээнд хоёр улсын түүх, соёлын талаарх өсвөр үеийнхний ойлголтыг гүнзгийрүүлэх, тэдний зохиож найруулан бичих ур чадварыг сайжруулах, хоёр улсын хоорондын найрсаг хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор “ЯПОН ОРНЫГ ХЭН САЙН МЭДЭХ ВЭ” зохион бичлэгийн уралдааныг ерөнхий боловсролын сургуулийн 9, 10 дугаар ангийн сурагчдын дунд 2007 оны 1 дүгээр сарын 20-ны өдрөөс 4 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл хугацаанд зарлаж байна. Зохион бичлэгийг 300-350 үгэнд багтаан цэвэр, гаргацтай бичнэ.

Уралдааныг улсын болон орон нутаг (аймаг, нийслэл)-ийн гэсэн 2 үе шаттайгаар зохион байгуулж байна.

Аймаг, нийслэлийн боловсрол, соёлын газар зохион бичлэгийг 2007 оны 4 дүгээр сарын 20-ны өдрөөс 5 дугаар сарын 4-ний өдөр хүртэл хүлээн авч, улсын түвшинд оролцуулах 5-аас хэтрэхгүй тооны зохион бичлэгийг 6 дугаар сарын 1-ны дотор багтаан шалгаруулж, 6 дугаар сарын 10-ны дотор Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд ирүүлнэ.

Уралдааныг зохион байгуулах үндэсний хороо уралдааны дүнг 2007 оны 6 дугаар сарын 20-ны дотор багтаан гаргаж, шагнал гардуулах ёслолын үйл ажиллагааг 2007 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн дотор зохион байгуулна.

Уралдааны шагнал: Зохион бичлэгийн уралдаанд I - V байр эзэлсэн суралцагчдыг Япон улсад аялах эрхийн бичгээр, харин VI—X байр эзэлсэн сурагчдыг Олон улсын Найрамдал зусланд амрах эрхийн бичгээр тус тус шагнана.

Лавлагаа: веб сайт-<http://www.mecs.pmis.gov.mn>, Утас-206409

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТӨВ

ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГА

МОНГОЛ УЛС ДАХЬ ЯПОН УЛСЫН ЭЛЧИН САЙДЫН ЯАМ
ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА
МОНГОЛ-ЯПОН ТӨВ